



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хүүхдийн анагаахын академитай хамтран зохион байгуулах “Эх, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд” сэдэвт сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны 11 сарын 15 өдрийн  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛД”  
СУРГАЛТАНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ**

2 өдрийн сургалт

№	Хэрэглэгдэх зүйлс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Бичиг хэргийн зардал	1 хүн	140	2000	280.000
2.	Гэрчилгээ	1 хүн	140	1000	140.000
3.	Цайны зардал	1 хүн/өдөр	140x2	2500	700.000
4.	Хоолны зардал	1 хүн/өдөр	140x2	7000	1.960.000
5.	Флаш	1 хүн	140	12.000	1.680.000
6.	Лекцийн заалны цагийн хөлс	1 цаг	2	120.000	240.000
<b>Нийт зардал</b>					<b>5.000.000 төг</b>

Хянасан:

Д.Гантуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Боловсруулсан:

П.Хэрлэн /АШУУИС, АУС, ХАТ/